

ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ЗАРЛАЛ

Огноо: 2023 оны 8 дугаар сарын 25-ны өдөр

Тендерийн нэр: “ЗҮҮН ЦАГААН ДЭЛ УУРХАЙН ХҮДЭР ЯЛГАХ ЦЕХИЙН ЗУРАГ ТӨСӨЛ”

Тендер дугаар: МРЦМ/202306543

“Монголросцветмет” ТӨҮГазар нь “Зүүн цагаан дэл”-ийн жоншны далд уурхайн дэргэд хайлуур жоншны хүдрийг бутлан шаардлага хангасан ширхэглэлийн хэмжээнд хүргэж өнгө болон лазерийн мэдрэгч бүхий 2ш ялгах төхөөрөмжөөр ялгах цехийн зураг төсөл зохиох, цех болон тоног төхөөрөмжүүдийг суурилуулах байршлыг тодорхойлж, тус цехэд шаардлагатай тоног төхөөрөмжүүдийн хүчин чадал, холболтын схем, зураг төсөл, тэдгээрийг суурилуулахад шаардагдах материалын тооцоо, төсөв зохиож батлуулах ажлыг гүйцэтгэх зөвлөх үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийг мэдүүлгээ ирүүлэхийг урьж байна.

Энэхүү зөвлөх үйлчилгээ нь тус үйлдвэрийн газрын Зүүн цагаан дэл хайлуур жоншны уурхайн олборлолт, баяжуулалтын ажиллагааны бэлтгэлийг хангахад чиглэгдэнэ.

Зөвлөх үйлчилгээ үзүүлэх мэдүүлгээ ирүүлж буй хуулийн этгээд нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14-16 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангасан талаарх нотлох баримтыг ирүүлнэ. Үүнд:

- Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар
- Борлуулалтын хэмжээ: Сүүлийн 2 жил буюу 2021, 2022 онуудын аль нэгд гүйцэтгэсэн борлуулалтын хэмжээ тендерийн үнийн саналын мөнгөн дүнгийн 30%-иас багагүй байна.
- Голлох мэргэжилтний чадавхийн талаарх мэдээлэл: Ажиллах боловсон хүчний ур чадвар, мэргэшил, туршлага
- Татвар, шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тодорхойлолтууд
- Гүйцэтгэгчээр ажилласан байх жилийн тоо: 2021, 2022 (Сүүлийн 2 жилд ижил төстэй хийж гүйцэтгэсэн зөвлөх үйлчилгээний ажлыг жагсаалт, гэрээний хуулбарыг гэрээ дүгнэсэн актын хамт ирүүлнэ)
- Тусгай зөвшөөрөл: ЗТ-3.3 эсвэл ЗТ-4.3 Хөнгөн ба хүнд үйлдвэрийн болон агуулахын барилга байгууламжийн технологийн зураг төсөл

Чадварыг нэмэгдүүлэх зорилгоор зөвлөхүүд түншлэл, туслан гүйцэтгэгчийн хэлбэрээр оролцож болно.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээс авч болох бөгөөд тендерийн нэмэлт мэдээлэл, тодруулгыг Захиалагч www.tender.gov.mn хаягаар цахим хэлбэрээр хүлээн авна.

Тендерт оролцогч мэдүүлгээ 2023 оны 9 дүгээр сарын 8-ны өдрийн 10:00 цагаас өмнө цахим худалдан авах ажиллагааны систем www.tender.gov.mn хаягаар цахимаар ирүүлнэ.

“МОНГОЛРОСЦВЕТМЕТ” ТӨҮГАЗАР